

## АГУУЛГА

<b>ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....</b>	<b>3</b>
<b>БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>4</b>
1.1. Төслийн байршил.....	4
1.2. Орчны төлөв байдал .....	5
1.3. Ордын геологийн нөөц .....	6
1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц.....	6
1.5. Уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа, ажиллах горим .....	7
1.5.1. Уурхайн хүчин чадал.....	7
1.5.2. Уурхайн ажиллах горим.....	7
1.6. Уурхайн талбайд ашиглалт явуулах дараалал.....	8
1.7. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл.....	8
1.8. Үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим.....	8
1.9. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл.....	10
<b>БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД .....</b>	<b>12</b>
2.1. Агаарын чанарт нөлөөлөх байдал .....	12
2.2. Хөрсний чанарт нөлөөлөх байдал.....	12
2.3. Усны чанарт нөлөөлөх байдал .....	12
2.4. Ургамалан нөмрөгт нөлөөлөх байдал.....	13
2.5. Амьтны аймагт нөлөөлөх байдал .....	13
2.6. Төсөл хэрэгжих орчны түүх соёлын дурсгалт зүйлс .....	13
2.7. Төслийн болзошгүй нөлөөллүүд.....	14
<b>БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН.....</b>	<b>15</b>
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	15
3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	16
3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	17
3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	20
3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	21
3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	21
3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	22
3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт .....	24
3.9. Аймаг, нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ .....	28
3.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .....	29
3.11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт .....	30
3.12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нэгтгэл.....	31
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>32</b>

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол.....	4
Хүснэгт 1.2. “Зүүн хэсэг” тоосгоны шаврын ордын батлагдсан геологийн нөөц.....	6
Хүснэгт 1.3. “Зүүн хэсэг” тоосгоны шаврын ордын үйлдвэрлэлийн нөөц.....	6
Хүснэгт 1.4. Уурхайн ажиллах горим .....	7
Хүснэгт 1.5. Уурхайн үндсэн тоног төхөөрөмж .....	8
Хүснэгт 1.6. Тоосго үйлдвэрлэлийн хүчин чадал төлөвлөлт.....	8
Хүснэгт 1.7. Тоосгоны үйлдвэрийн ажиллах горим, хүчин чадал.....	9
Хүснэгт 1.8. Тоосго үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжүүд.....	11
Хүснэгт 2.1. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа .....	14
Хүснэгт 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....	15
Хүснэгт 3.2. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	22
Хүснэгт 3.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	23
Хүснэгт 3.4. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.....	29
Хүснэгт 3.5. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь.....	30
Хүснэгт 3.6. 2022 оны БОМТ-ний нийт зардал, биелэлтийн үзүүлэлтүүдийн харьцуулалт .....	31

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Төслийн талбайн байршлын зураг .....	4
Зураг 1.2. Тоосго үйлдвэрлэлийн технологийн дамжлага схем.....	10
Зураг 1.3. Тоосго үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн дамжлага схем .....	11
Зураг 3.1. Уурхайн талбайд нөхөн сэргээлт хийж буй байдал .....	16
Зураг 3.2. Нөхөн сэргээлт хийсний дараах байдал.....	16
Зураг 3.3. Нийгмийн хариуцлагын гэрээ, 2021-2022 он.....	17
Зураг 3.4. Инновацийн төв байгуулах ажилд оролцсон илтгэх хуудас-1 .....	18
Зураг 3.5. Инновацийн төв байгуулах ажилд оролцсон илтгэх хуудас-2.....	19
Зураг 3.6. Инновацийн төв байгуулах ажилд оролцсон илтгэх хуудас-3.....	20
Зураг 3.7. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслүүд.....	21
Зураг 3.8. Аюулгүй ажиллагааны самбар.....	21
Зураг 3.9. Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ, төлбөрийн баримт .....	23
Зураг 3.10. Хөрсний шинжилгээний хариу .....	24
Зураг 3.11. Усны шинжилгээний хариу-1 .....	25
Зураг 3.12. Усны шинжилгээний хариу-2 .....	26
Зураг 3.13. Агаар, дуу чимээний хэмжилтийн үр дүн .....	27
Зураг 3.14. Төвийн бүсийн хурдан морины уралдааныг дэмжиж оролцсон итгэх хуудас .....	28

### ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

№	ҮЗҮҮЛЭЛТ	УТГА
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“ХЭЛТРЭГЭ” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн мэдээлэл	Улсын бүртгэлийн дугаар: 2911002087 Бүртгэсэн огноо: 2006.11.30 Регистрийн дугаар: 4489659
3	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 4-р хороо, Нисэх 4-14 тоот
4	Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын мэдээлэл	Захирал: Ж.Буянтогтох Утас: 9909-5707
5	Төслийн нэр	Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Зүүн хэсэг” нэртэй тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах, тоосго үйлдвэрлэх төсөл
6	Төслийн байршил	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо
7	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-012558
8	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Олгосон огноо : 2007.07.18
9	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ	26.41 га
10	Ордын батлагдсан геологийн нөөц	787.54 мян.м <sup>3</sup>
11	Ордын үйлдвэрлэлийн нөөц	774.72 мян.м <sup>3</sup>
12	Шавар олборлолтын жилийн хүчин чадал	12.14 мян.м <sup>3</sup>
13	Тоосго үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал	3.5 сая ширхэг

## БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


### 1.1. Төслийн байршил

“Зүүн хэсэг” тоосгоны шаврын уурхай нь засаг захиргааны нэгжийн хувьд Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт хамаарах бөгөөд Улаанбаатар хотын төвөөс 36 км зайд байр зүйн зургийн L-48-11 тоот хавтгайд оршино.

Уг орд байрлаж буй нийт 26.41 га талбай бүхий MV-012558 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцолыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1.1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол

№	Тусгай зөвшөөрлийн дугаар, талбайн нэр	Талбайн хэмжээ, га	Солбилцол	
			Өргөрөг	Уртраг
1	MV-012558	26.41	47° 44' 31.18"	107° 17' 46.37"
2			47° 44' 31.18"	107° 17' 21.37"
3			47° 44' 47.77"	107° 17' 21.87"
4			47° 44' 47.77"	107° 17' 46.37"



Зураг 1.1. Төслийн талбайн байршлын зураг

## 1.2. ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

**Уул зүй:** Уул зүйн хувьд ордын дүүрэг нь Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт Налайхын хотгорт хамаарагдана. Энэхүү хотгорын туйлын өндөржилт нь далайн түвшнээс дээш 1400-1420 м (ордын талбайн хэсэгт) байна. Орд байрлаж буй хотгор нь баруунаас зүүн тийш чиглэлтэй, гонзгойдуу хэлбэртэй, төв хэсэгтээ хонхордуу, төв, зүүн талдаа тэгшивтэр талархаг гадаргуу үүсгэжээ.

**Усан сүлжээ:** Ордын талбайн орчимд усан сүлжээ муу хөгжсөн ба бороо хургүй үед ширгэдэг Налайхын голоос өөр урсгал устай гол үгүй. Харин ордын хойгуур 8-10 км зайтай Туул гол урсаж өнгөрдөг.

**Цаг уур:** Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын болон хоногийн температур эрс хэлбэлзэлтэй, атмосферийн тунадасны хэлбэлзэл 120-220 мм бөгөөд жилийн дунджаар 200 мм хүрнэ. Анхны цас 9-р сарын 15-ны үеэр, сүүлчийн цас 5-р сарын 15-ны үеэр орох жишээтэй байдаг. Хамгийн халуун нь 7-р сард, хамгийн хүйтэн нь 1-р сард болдог. Хамгийн их хур тунадас унадаг улирал нь зун байна. Өвөл хөрс нь 3-5 м гүн хөлддөг. Цэвдэгшилт нилээд тархалттай бөгөөд газрын тогтоц, чулуулгийн литологийн бүтцээс хамаарч нам дор газар 1.5-2.0 м, өндөрлөг хэсэгт 3.5-5.0 м-т тохиолдоно. Ордын дүүрэг нь газар хөдлөлтийн VII-VIII бүсэд хамаарна.

**Хүн ам зүй:** Налайх тосгон нь 7 мянга гаруй өрхийн 26 мянга орчим хүн амтай бөгөөд халх, казак, буриад, урианхай, дөрвөд зэрэг ястнуудаас бүрдэнэ.

**Дэд бүтэц:** Налайх тосгонд соёлын ордон, эмнэлэг, дэлгүүр, зоогийн газар, харилцаа холбоо, зочид буудал, халуун ус, үсчин гоо сайхан, 12 жилийн сургалттай ЕБС, МСҮТ, хувийн бага болон дунд сургууль, хувийн эзэмшлийн нүүрсний уурхайнууд, цахилгаан станц, малын гаралтай түүхий эдийн зах, гадаадын болон дотоодын хувийн хөрөнгө оруулалттай оёдлын үйлдвэр, тоосгоны үйлдвэр зэрэг үйлдвэрлэл үйлчилгээний газруудтай. Нийтийн зориулалттай 2-5 давхар орон сууц тосгоны барилгажилтын 17 хувийг эзэлдэг. Ундны болон ахуйн хэрэгцээ, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг 4.2 л/с-ийн нийлбэр ундаргатай ус татах төхөөрөмжийн тусламжтайгаар Туул голын хөндийн аллювийн хурдас дахь газар доорхи усаар хангадаг.

**Зам харилцаа:** Налайх дүүрэг нь зам харилцааны хувьд Улаанбаатар хоттой хатуу хучилттай болон төмөр замаар холбогддог. Чиглэлийн автобус, галт тэрэг болон бусад машин техникийн саадгүй үйлчилгээтэй. Тосгоны баруун талаар Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай зам, хойд талаар Улаанбаатар-Хэнтий чиглэлийн мянганы зам дайрч өнгөрдөг. Зүүн аймгуудын автотээврийн гол зам дайран өнгөрдөг тул зүүн аймгуудтай харилцах зам, харилцааны зангилаа болдог.

### 1.3. ОРДЫН ГЕОЛОГИЙН НӨӨЦ

Геологийн тогтоцын шинж чанар, ашигт малтмалын нөөцийн хэмжээгээрээ “Зүүн хэсэг” тоосгоны шаврын орд нь ордын нөөцийн ангилалаар II зэргийн ордод хамаарах ба ашигт малтмалын зузаан ба чанар тогтвортой, хэмжээний хувьд дунд зэргийн ордод хамаарна.

Нийт ордын хэмжээнд шаврын дундаж зузаан 3.07 м, нийт тоосгоны шаврын нөөц бодитой (В) зэрэглэлээр 787.54 мян.м<sup>3</sup>, хуулах хөрсний дундаж зузаан 0.3 м байна.

*Хүснэгт 1.2. “Зүүн хэсэг” тоосгоны шаврын ордын батлагдсан геологийн нөөц*

№	Нөөцийн блокийн дугаар	Талбайн хэмжээ, м <sup>2</sup>	Тоосгоны шаврын дундаж зузаан, м	Тоосгоны шаврын нөөц, м <sup>3</sup>	Хуулах хөрсний зузаан, м	Хуулах хөрсний эзэлхүүн, м <sup>3</sup>	Хуулах хөрс, шаврын харьцаа
1	В - I	89465.45	3.11	278237.54	0.32	28628.94	9.7
2	В - II	81945.01	3.02	247473.93	0.31	25402.95	9.74
3	В - III	85009.9	3.08	261830.49	0.28	23802.77	11
-	<b>Нийт В зэргээр</b>	<b>256420.36</b>	<b>3.07</b>	<b>787541.96</b>	<b>0.3</b>	<b>77834.66</b>	<b>10.11</b>
-	<b>Ордын хэмжээнд</b>	<b>256420.36</b>	<b>3.07</b>	<b>787541.96</b>	<b>0.3</b>	<b>77834.66</b>	<b>10.11</b>

### 1.4. ОРДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ

“Зүүн хэсэг” тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах үеийн үйлдвэрлэлийн нөөц нь 774.72 мян.м<sup>3</sup> байхаар ТЭЗҮ-д тооцож тусгасан байна.

*Хүснэгт 1.3. “Зүүн хэсэг” тоосгоны шаврын ордын үйлдвэрлэлийн нөөц*

№	Нөөцийн зэрэг, блокийн дугаар	Блокийн талбай, мян.м <sup>2</sup>	Нөөцийн зэрэг, блокийн дугаар	Нийт уулын цул, мян.м <sup>3</sup>	Хуулах хөрсний зузаан, м	Хөрс хуулагт, мян.м <sup>3</sup>	Олборлох давхаргын зузаан, м	Шавар олборлолт, мян.м <sup>3</sup>	Хөрс хуулагтын коэффициент, м <sup>3</sup> /м <sup>3</sup>
1	В-I	89.465	В'-I	306.87	0.37	33.1	3.06	273.76	0.12
2	В-II	81.945	В'-II	272.88	0.36	29.5	2.97	243.38	0.12
3	В-III	85.01	В'-III	285.63	0.33	28.05	3.03	257.58	0.11
-	<b>Нийт</b>	<b>256.42</b>	<b>Нийт</b>	<b>865.38</b>	<b>0.35</b>	<b>90.66</b>	<b>3.02</b>	<b>774.72</b>	<b>0.12</b>

## 1.5. Уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа, ажиллах горим

### 1.5.1. Уурхайн хүчин чадал

Уурхайн хүчин чадлыг техник-эдийн засгийн үндэслэлд жилд 12.14 мян.м<sup>3</sup> тоосгоны шавар олборлон боловсруулахаар тооцож тусгасан.

### 1.5.2. Уурхайн ажиллах горим

“Зүүн хэсэг” тоосгоны шаврын уурхай нь улирлын чанартай явагдах бөгөөд 4-р сарын 15-аас 9-р сарын 30-ныг хүртэл жилд нийтдээ 5 сар ажиллана.

Уурхайн ажиллах горимын үзүүлэлтүүдийг хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн тооцоолж дараах хүснэгтэнд нэгтгэн харууллаа.

*Хүснэгт 1.4. Уурхайн ажиллах горим*

№	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга	Тайлбар
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365	-
2	Өвлийн улирлын сул зогсолт	хоног	215	9-р сарын 30-аас 04-р сарын 15 хүртэл
3	Уурхайн ажиллах хоног	хоног	153	04-р сарын 15-аас 9-р сарын 30 хүртэл
4	Баяр ёслолын амралт	хоног	6	Хөдөлмөрийн тухай хуулийн 76.1.4, 76.1.5, 76.1.10-р зүйлийн дагуу
5	Цаг агаарын саатал	хоног	7	-
6	Засвар үйлчилгээ	хоног	7	Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус
7	Уурхайн бэлтгэл ажил	хоног	7	-
8	Жилд ажиллах бодит хоног	хоног	133	-
9	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	1	-
10	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	8	-
11	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.90	90%
12	Нэг ээлжин дэх цэвэр ажлын цаг	цаг	7.2	Цаг ашиглалт тооцсон
13	Хоногт ажиллах бодит цаг	цаг	7.2	Цаг ашиглалт тооцсон
14	Жилд ажиллах бодит цаг	цаг	958	Цаг ашиглалт тооцсон
15	Уурхайн цагийн хүчин чадал	м <sup>3</sup> /цаг	12.68	Цаг ашиглалт тооцсон
16	Уурхайн ээлжийн хүчин чадал	м <sup>3</sup> /ээлж	91.30	Хоногт 8 цагийн 1 ээлжээр ажиллана
17	Уурхайн хоногийн хүчин чадал	м <sup>3</sup> /хоног	91.30	
18	Уурхайн жилийн хүчин чадал	м <sup>3</sup> /жил	12142.86	Жилд нийтдээ 133 хоног ажиллана.

Баяр ёслолын амралт, цаг агаарын саатал, засвар үйлчилгээ, уурхайн бэлтгэл ажил зэргийг тооцоход “Зүүн хэсэг” тоосгоны шаврын уурхай нь хоногт 8 цагийн 1 ээлжээр жилд бодитоор 133 хоног буюу 958 цаг ажиллана.

## 1.6. УУРХАЙН ТАЛБАЙД АШИГЛАЛТ ЯВУУЛАХ ДАРААЛАЛ

“Зүүн хэсэг” нэртэй тоосгоны шаврын ордод ашиглалт явуулах үйл ажиллагаа нь дараах технологийн дагуу явагдана.

### *Шавар олборлолт:*

#### **ШИМТ ХӨРС ХУУЛАЛТ ► ТООСГОНЫ ШАВАР ОЛБОРЛОЛТ**

### *Тоосго үйлдвэрлэл:*

#### **ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ► ХАТААХ ► ШАТААХ ► БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД НИЙЛҮҮЛЭХ.**

Үүний зэрэгцээ уурхайн тээврийн замыг цэвэрлэх, хуурайшилт ихтэй үед тоосжилтыг бууруулах мөн тоног төхөөрөмжид засвар, үзлэг үйлчилгээ хийх гэх мэт туслах ажлууд хийгдэнэ.

## 1.7. УУРХАЙН ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ИЖ БҮРДЭЛ

Уурхайд олборлолтын үйл ажиллагаа явуулахаас өмнө үржил шимт хөрсний үеийг утгуурт ачигчаар хусаж бөөгнүүлэн автосамосвалд ачиж тээвэрлэн тусгай овоолгод байршуулж стандартын дагуу хадгална.

Тухайн жилийн ашиглалтанд өртөх талбайн шимт хөрсийг хуулсаны дараа нээгдсэн шаврын үеийг экскаватораар сийрэгжүүлэн ухаж автосамосвалд ачин цааш үйлдвэрийн талбай руу тээвэрлэж тоосгоны шавар бутлан ангилах төхөөрөмжийн хүлээн авах туузан дамжуулагчид хүргэнэ.

### *Хүснэгт 1.5. Уурхайн үндсэн тоног төхөөрөмж*

№	Техник	Марк	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Экскаватор (уулын цул)	Hyundai R500LC-7	1	1.2 м <sup>3</sup>
2	Автосамосвал (уулын цул)	Howo ZZ3257	1	20 тн
3	Бульдозер	Shantui SD16	1	131 кВт
4	Утгуурт ачигч	ZL50G	1	3.0 м <sup>3</sup>
-	<b>Нийт</b>	-	<b>3</b>	-

## 1.8. ҮЙЛДВЭРИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ

“Зүүн хэсэг” тоосгоны шаврын уурхайн дэргэдэх тоосгоны үйлдвэр нь жилд дунджаар 3.5 сая ширхэг тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай.

### *Хүснэгт 1.6. Тоосго үйлдвэрлэлийн хүчин чадал төлөвлөлт*

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Жилд	Нийт үйлдвэрлэлийн хугацаанд
1	Үйлдвэрлэх тоосгоны хэмжээ	мян.ш	3571.43	223301.92
2	Тоосгоны технологийн хаягдал, 2%	мян.ш	71.43	4557.18
<b>3</b>	<b>Борлуулах</b>	<b>мян.ш</b>	<b>3500</b>	<b>227859.10</b>



Тоосгоны үйлдвэр нь жилд дунджаар 3.57 сая ширхэг тоосго үйлдвэрлэх ба технологийн хаягдлыг хасаж тооцсоноор 3.5 сая ширхэг тоосгыг зах зээлд нийлүүлнэ.

Тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь уурхайн үйл ажиллагаатайгаа адил улирлын чанартай явагдах бөгөөд 4-р сарын 15-наас 5-р сарын 01-нийг хүртэл бэлтгэл ажил, 5-р сарын 01-нээс 09-р сарын 30-ныг хүртэл тоосго үйлдвэрлэл, хатаалт, шатаалтын ажил явагдана.

Тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь хоногт 8 цагийн 1 ээлжээр ажиллах горимыг барина. Ингэснээр уг үйлдвэр нь жилдээ 133 хоног буюу 958 цаг ажиллах юм.


*Хүснэгт 1.7. Тоосгоны үйлдвэрийн ажиллах горим, хүчин чадал*

№	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга	Тайлбар
1	Баяр ёслолын амралт	хоног	7	Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.1, 4.1.5, 4.1.10-р зүйлийн дагуу
2	Цаг агаарын саатал	хоног	7	-
3	Засвар үйлчилгээ	хоног	7	Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус
4	Бэлтгэл ажил	хоног	14	Уурхайн бэлтгэл ажил
5	Жилд ажиллах бодит хоног	хоног	133	-
6	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	1	-
7	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	8	Уртасгасан цагаар
8	Цаг ашиглалтын итгэлцүүр	-	0.9	90%
9	Жилд ажиллах бодит цаг	цаг	958	Цаг ашиглалт тооцсон
10	Уурхайн цагийн хүчин чадал	мян.ш/цаг	3.73	Цаг ашиглалт тооцсон
11	Уурхайн ээлжийн хүчин чадал	мян.ш/ээлж	26.85	Хоногт 8 цагийн 1 ээлжээр ажиллана
12	Уурхайн хоногийн хүчин чадал	мян.ш/хоног	26.85	
13	Уурхайн жилийн хүчин чадал	мян.ш/жил	3571.0	Жилд нийтдээ үйлдвэр 133 хоног ажиллана.

Тоосгоны үйлдвэрийн хоногийн хүчин чадал 26.85 мян.ш, цагийн хүчин чадал 3.73 мян.ш байхаар тооцоо гарч байна.

**Тоосго үйлдвэрлэх технологи:**

Тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь ерөнхийдөө: ТҮҮХИЙ ЭД, МАТЕРИАЛЫГ БУТЛАХАД ► ТҮҮХИЙ ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ► ХАТААХ ► ШАТААЖ БОЛОВСРУУЛАХ ► ЭЦСИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД НИЙЛҮҮЛЭХ гэсэн технологийн дарааллаар ажиллана.



Зураг 1.2. Тоосго үйлдвэрлэлийн технологийн дамжлага схем

### 1.9. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл

Тоосго үйлдвэрлэх үйл ажиллагаа нь түүхий эд, материалыг бутлан үйлдвэрлэлд бэлдэх, тоосго үйлдвэрлэх, хатаах, шатааж боловсруулах, эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх гэсэн ерөнхий шат дараалалтай явагдана.

*Хүснэгт 1.8. Тоосго үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжүүд*

№	Тоног төхөөрөмжүүд	Марк	Хүчин чадал	Тоо
1	Утгуурт ачигч	ZL50G	3 м <sup>3</sup>	1
2	Хайрцагт гэжээгүүр	ZYM50	10-25 м <sup>3</sup> /цаг	1
3	Алхат бутлуур	GP600x500	20-30 м <sup>3</sup> /цаг	2
4	Хос голт зуурагч	SJ2500	25-30 м <sup>3</sup> /цаг	2
5	Вакум хэвлэгч	ZYM30	4-6 мян.ш/ц	1
6	Гулдмай таслагч	Гидрийн	1-1.3 м/сек	1
7	Тоосго зүсэгч	Автомат синхрон	26 удаа/мин	1
8	Туузан дамжуулагч	DS50x8	1.3 м/сек	4



*Зураг 1.3. Тоосго үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн дамжлага схем*

## **БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД**

### **2.1. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ**

Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос, шороо болон угаарын хорт хий агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно.

Шавар олборлох уурхайд:

- *Хөрс хуулах, шавар олборлох үед тоос үүсэх,*
- *Тээврийн хэрэгсэл явах үед боссон автозамын тоос,*
- *Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтын хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий,*
- *Уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос,*
- *Хөрс болон шаврыг тээвэрлэх үед үүсэх тоос, шороо нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болдог.*

Үүнээс уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаар орчныг байнга бохирдуулдаг бөгөөд салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшил зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улиралд нөлөөллийн хэмжээ харилцан адилгүй байдаг.

### **2.2. ХӨРСНИЙ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ**

Хүнд машин механизмын хөдөлгөөнөөс хөрс эвдрэх, элэгдэлд орох зэргээр хөрс, ургамлын хүний үйл ажиллагаанд өртөж буй талбайн хязгаар нь түүнээс нилээд хол зайд, наад зах нь 500-1000 м болж, нөлөөллийн хүрээ нь тэлж болохыг цаашид анхаарах шаардлагатай юм.

Шавар олборлох ажлын байгаль орчинд үзүүлэх экологийн гол үр дагавар нь газрын хурдсыг эвдэж, нүх, карьер үүсэх, улмаар агаарын тоосны бохирдол ихсэх, энэ нь ойр орчимдоо тархах, байгаль хамгаалах шаардлагатай арга хэмжээ авч сөрөг нөлөөллийг бууруулахгүй бол цөлжилт явагдах, цаашид хүрээгээ тэлэхэд хүргэж болзошгүй.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй шатах тослох материалын хадгалалт, ашиглалтанд байнгын хяналт тавьж болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх шаардлагатай болно.

### **2.3. УСНЫ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ**

Уурхайн орчим урсгал ус байхгүй бөгөөд геологи хайгуулын үед шаврын олборлолтын давхаргад гүний ус илрээгүй нилээд гүнд байгаа учир энэ төрлийн нөлөөлөл бага юм.

#### **2.4. УРГАМАЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ**

Төсөл хэрэгжих явцад тухайн орд ашиглах газрын ургамлын бүрхэвч агаар, хөрсний бохирдлоос үүдэн ихээхэн хэмжээний доройтолд орсон нь ажиглагдаж байсан.

#### **2.5. АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ**

Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймгийн төлөөлөгчдийн идэш тэжээлийн хэлхээ холбоо тасрах, амьдрах нутгийн хүрээ хумигдах, нүүдэллэх талбай хаагдах, техникийн дуу чимээ, доргио чичиргээ, бензин тосны үнэр зэргээс тайван байдал нь алдагдаж, амьдрах орчноосоо дайжих байдлаар тухайн экосистем тодорхой хэмжээгээр өөрчлөгдөнө.

Сээр нуруугүй амьтад, ялангуяа шавж, аалз хэлбэртэн байгалийн аливаа нэг биоценозод тохиолдох нийт амьтдын биомассын ихэнх буюу 90 хүртэл хувийг бүрдүүлэх бөгөөд тухайн орчинд явагдаж байгаа бодис, энергийн эргэлт, хувирлыг хэвийн явуулах, түргэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Ийм учраас хөрсний амьтдын зонхилох хэсгийн зүйл, тэдгээрийн тоо толгойн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноор тухайн экосистемийн тогтолцоонд өөрчлөлт хувьсал гарах нь дамжиггүй.

Шатах, тослох материал хадгалах, зөөвөрлөх үед асгах, хатуу хог хаягдлыг ил задгай хаях, эвдэрсэн газрыг хөрсжүүлэх ажил орхигдоход хөрсөнд амьдрагч сээр нуруугүйтэн, жижиг мэрэгчид, тэдгээрээр хооллогч хөхтөн, шувуудын тоо толгой цөөрөх үйл явц ажиглагдана. Энэ нь амьтан, ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан шүтэлцээтэйгээр экосистемийг бүрэлдүүлэх биологийн зүй тогтол юм.

#### **2.6. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛС**

Тус тоосгоны шаврын ордын талбай нь байгалийн цогцолборт газарт хамаарахгүй бөгөөд түүх, соёлын дурсгалт зүйл талбайн хэмжээнд байхгүй. Хэрэв олборлолтын явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл дүүргийн болон нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, холбогдох мэргэжлийн байгууллагуудад хандах хэрэгтэй.

## 2.7. Төслийн болзошгүй нөлөөллүүд

Хүснэгт 2.1. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
<b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Ургамлын бүтцийн өөрчлөлт	X				X		X			X
Хөрсний элэгдэл, эвдрэл	X				X		X	X		
Геологийн тогтоцын өөрчлөлт	X				X		X	X		
Зэрлэг амьтдын орон зай		X		X			X			X
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										X
<b>2. Байгалийн нөөц, ашиглалт</b>										
Газрын гадаргын нөөц баялаг	X				X		X		X	
Бэлчээрийн байдал	X				X		X		X	
Эрдэс түүхий эдийн нөөц	X				X		X	X		
Эрчим хүчний нөөц										
<b>3. Байгаль, орчны өөрчлөлт</b>										
Ундны усны чанар, хэмжээ	X									
Урсгал усны хэрэгцээ	X									
Агаарын бохирдол				X					X	
Хөрсний эвдрэл, бохирдол					X		X		X	
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		X								X
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b>										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	X				X		X		X	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	X				X		X		X	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
<b>5. Эдийн засаг, нийгмийн асуудал</b>										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	X			X					X	
Орон нутгийн орлого нэмэгдэх	X			X			X	X		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	X			X					X	
Ажлын байр нэмэгдэх	X									X
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	X			X					X	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		X		X						X
<b>6. Бусад нөлөөлөл</b>										
Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	X				X		X		X	
Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, ба грунтын усыг бохирдуулах	X						X			X
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	X			X		X				X
Хүчтэй салхи, уруйн үер	X			X			X	X		
<b>Дүн</b>	<b>19</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>1</b>	<b>14</b>	<b>5</b>	<b>10</b>	<b>8</b>

### БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

#### 3.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлсэн ба холбогдох тайлбар, үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд харууллаа.

*Хүснэгт 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Хэрэгжүүлэгч	Зардал, мян.төг	Гарсан үр дүн
<b>Хөрсөн бүрхэвч</b>					
1	Ажилчдад шатах, тослох материалтай хэрхэн харьцах, түүнээс үүсэх эрсдэлээс хэрхэн сэргийлж, ямар арга хэмжээ авах талаар сургалт зохион байгуулсан	Жилд 1 удаа	“Хэлтрэгэ” ХХК	100.0	Шатах тослох материалын асгаралтаас хөрс бохирдохоос сэргийлсэн
2	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг сайжруулсан	Төслийн үйл ажиллагааны явцад	“Хэлтрэгэ” ХХК	100.0	Хөрс элэгдэл эвдрэлд орох, тоосжилтоос сэргийлсэн
3	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, хөрс, гүний ус бохирдохоос сэргийлэх, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авч ажилласан.	Байнга	Байгаль орчны мэргэжилтэн	100.0	Хөрс бохирдохоос сэргийлсэн
<b>Агаарын орчин</b>					
1	Шаврын олборлолтын үед тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн	Байнга	“Хэлтрэгэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр	Тоосжилтоос сэргийлсэн
2	Тоос шороотой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдыг тоосжилтоос хамгаалах зорилгоор өдөрт нормын сүү, цагаан идээ өгсөн	Байнга	“Хэлтрэгэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр	Ажилчдын эрүүл мэндэд анхаарсан
3	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авч ажилласан	Төслийн үйл ажиллагааны явцад	“Хэлтрэгэ” ХХК	100.0	Агаарын бохирдлоос сэргийлсэн
<b>Усан орчин</b>					
1	Үер усны аюулаас сэргийлэхийн тулд хамгаалалтын далан байгуулсан	Төслийн үйл ажиллагааны явцад	“Хэлтрэгэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр	Үер усны аюулаас сэргийлсэн
<b>Нийт дүн</b>			<b>400.0</b>		

### 3.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд нийтдээ 0.1 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж өөрийн үйлдвэрийн хог хаягдал болон өмнөх олон жилийн хур хог хаягдлыг түрж тэгшлэх, зөөж булаах ажлуудыг гүйцэтгэлээ.

Нөхөн сэргээлтийн ажилд энэ онд нийтдээ 1.5 сая төгрөг зарцууллаа.



*Зураг 3.1. Уурхайн талбайд нөхөн сэргээлт хийж буй байдал*



*Зураг 3.2. Нөхөн сэргээлт хийсний дараах байдал*



### 3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт


Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд тодорхой ажил төлөвлөөгүй ба НБОГ-аас санал болгосон ажлыг тухай бүрт нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

НБОГ-с “Налайхын барилгын материал үйлдвэрлэгчдийн Титэм холбоо” НҮТББ-аар дамжуулан дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн дагуу Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас байгуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж буйг мэдэгдсэн боловч уг ажил энэ онд хараахан хэрэгжиж амжаагүй байна.

Манай компани цаашид НБОГ болон холбогдох шатны байгууллагуудаас санал болгож зохион байгуулах дүйцүүлэн хамгаалах ажлуудад идэвхитэй оролцох болно.

Манай компани Налайх дүүрэгтэйгээ жил бүр “Нийгмийн хариуцлагын гэрээ”-г шинэчлэн байгуулж хамтран ажилладаг болно.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Налайх дүүргийн Засаг дарын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Инноваци, гарааны бизнес, оюуны үйлвэрлэлийг дэмжих инновацийн төв” байгуулах ажлыг дэмжиж 1.0 сая төгрөгийн хандив өгч оролцов.



Зураг 3.3. Нийгмийн хариуцлагын гэрээ, 2021-2022 он

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ,  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

Инновацийн төв байгуулсан тухай

2022 оны 2 дугаар сарын 22

Налайх дүүрэг

Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Инноваци, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг дэмжих инновацийн төв байгуулна” заалтын хүрээнд залуусын бизнес сэтгэлгээг хөгжүүлэх, гарааны бизнес эхлүүлэх шинэ шинэлэг санааг нээж олох, ажиллаж суралцахад таатай орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн 54м<sup>2</sup> талбайг бүрэн засварлаж, “Цагаан хулан” ХХК-иар /Сайн тавилга/ компьютерийн ширээ, суудалтай номын сан, кофены хэсэг, хувцасны шкаф, 10 хүний суудалтай ширээ зэрэг иж бүрэн тавилгыг захиалгаар хийлгэн тохижууллаа.

Тус ажлыг нийгмийн хариуцлагын хүрээнд дүүргийн “Тоосго үйлдвэрлэгчдийн Титэм холбоо”-ны гишүүн 10 аж ахуйн нэгжийн дэмжлэг тусламжтайгаар байгуулав.

**Засварын өмнөх байдал:**



**Интерьер дизайны загвар зураг:**



**Засварын ажил хийгдэж буй байдал:**

Зураг 3.4. Инновацийн төв байгуулах ажилд оролцсон илтгэх хуудас-1



***Инновацын төвийг тохижуулсан байдал:***



*Зураг 3.5. Инновацын төв байгуулах ажилд оролцсон илтгэх хуудас-2*



**Дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгжийн мэдээлэл:**

№	Дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгжийн нэр	Он сар	Мөнгөн дүн/ төгрөг/
1.	Төгс Эрхэс ХХК	2022 оны 1 сар	2 сая
2.	НК ХХК		2 сая
3.	Хонг Да Интернэшнл ХХК		2 сая
4.	Гэрэлт-Орд ХХК		2 сая
5.	Хоргын чулуу ХХК		2 сая
6.	Кенже ХХК		2 сая
7.	Угалзан цамхаг ххк		2 сая
8.	Баян Эрдэнэ хүрд ХХК		2 сая
9.	Хэлтрэгэ ХХК		1 сая
10.	Цагаан ташаа ХХК		1 сая
Нийт дүн			<b>20 сая</b>

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, НОГООН  
ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ  
ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАГЧ БӨГӨӨД  
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ *Ц.Тунгалаг*  
2022 оны 02 сарын 22 өдөр



ХЯНАСАН:  
ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА *Ц.Тунгалаг*  
2022 оны 02 сарын 22 өдөр

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:  
ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИТЭН *М.Байгаль* М.БАЙГАЛЬ

Зураг 3.6. Инновацийн төв байгуулах ажилд оролцсон илтгэх хуудас-3

**3.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

- ✓ Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ төлөвлөгдөөгүй болно.

### 3.5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- ✓ Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй ба 2022 оны ашиглалтын явцад түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй болно.

### 3.6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Ажилчдын эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын дагуу ажилчдад хамгаалах хэрэгсэл, нүдний шил, хамар амны маск, чихний бөглөө, хатуу малгай, бээлий, тохиромжтой гутал зэрэг ХАБЭА-н хэрэгслээр бүрэн хангаж, байнга өмсүүлж, хэрэглүүлж хэвшүүлсэн. Төслийн үйл ажиллагаа эхэлсэнээс хойш ямар нэгэн осол аваар гараагүй болно.



Зураг 3.7. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслүүд



Зураг 3.8. Аюулгүй ажиллагааны самбар

Бид ажилчдынхаа эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж гэнэтийн болон болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахаар хичээж ажиллаж байгаа ба манай төслийн үйл ажиллагаа эхэлсэн үеэс эхлэн ямар нэгэн осол аваар гараагүй болно.

*Хүснэгт 3.2. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Зардал, мян.төг	Хэрэгжүүлсэн хугацаа
1	Автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулсан	250.0	Төслийн үйл ажиллагааны явцад
		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад байрлуулсан	250.0	Уурхай эхлэх үед
3	Хүчтэй аадар бороо, аянга цахилгааны улмаас ажлын байрны аюулгүй байдал, цахилгаан тасрах, хүний амь нас, эрүүл мэнд хохирох	Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед үйлдвэрийн ажлыг түр зогсоож байсан	-	Төслийн хугацаанд
4	Ажилчид бэртэх, амь нас эрсдэх, шавар олборлолт болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ажилдаа гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажилласан	-	Өдөр бүр
		Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан	250.0	Жилд 1 удаа
5	Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс тээврийн хэрэгслүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж, бэртээх гэх мэт осол аваар гарах	-Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулсан, -Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулсан	250.0	Жил бүр
<b>Нийт</b>			<b>1000.0</b>	

**3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт**

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгахын тулд Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Наянбаяртай 2022 оны 06-р сарын 03-ны өдөр № 0000129 тоот гэрээг 6 сарын хугацаатай байгуулан ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулж хадгалан тээвэрлүүлэх ажлыг гүйцэтгүүлж байна.

Энэхүү гэрээгээр Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам”, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн ИТХ-ын 2012 оны 61-р тогтоол, Дүүргийн засаг даргын 2013 оны 04-р сарын 26-ны өдрийн 165-р захирамжийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байгаа болно.



### 3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрс, усны шинжилгээ, агаар, дуу чимээний хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэлээ. Энэ ажилд нийтдээ 158.0 мянган төгрөг зарцуулсан болно.



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt1@gmail.com](mailto:bohzt1@gmail.com)



**БАЙГАЛЬ**  
ОРЧИН ХЭМЖИЛЭГЭЭНИЙ ТӨВ ЛАБОРАТОРИ

**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/ №	: 2022/ 518
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: " Хэлтрэг " ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Д.Сувд, агаарын хэсгийн техникч
Дээжийн тоо, төрөл	: 1, хөрсний сорьц
Хүлээн авсан огноо	: 2022.09.20
Дээжийн тодорхойлолт	: Улаанбаатар хот-Налайх дүүрэг
Шинжилгээний аргын стандарт	: САЗ А01:2022
Шинжилсэн огноо	: 2022.09.22
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн:	

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Кобальт (Co)	Стронци (Sr)
		мг/кг							
1	Бааюу орчим	<0.005	23.4	0.6	<0.005	0.0	24.4	37.1	368.3
	<b>MNS 5850:2019 / ЗДХ/</b>	<b>3</b>	<b>100</b>	<b>2</b>	<b>150</b>	<b>300</b>	<b>100</b>	<b>50</b>	<b>800</b>

Шинжилгээ гүйцэтгэсэн :  Д.Баярхулан  
Хөрсний хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан :  Б.Даваасүрэн  
Хөрсний хэсгийн инженер

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй

Зураг 3.10. Хөрсний шинжилгээний харуу





**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt@gmail.com](mailto:bohzt@gmail.com)



**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№	: 2022/ Ц-171
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Хэлтэргэ” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал	: Д.Сувд, БОХЗТЛ
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьцыг авсан огноо	: 2022.09.20
Сорьцын тодорхойлолт	: Усны сорьц
Шинжилгээний аргын стандарт	<b>MNS ISO 6836:2020, MNS 6833:2020</b> <b>MNS ISO 7150-1:2006, MNS 6779:2019</b> <b>MNS 6834:2020, MNS ISO 6878:2001</b> <b>MNS 4430:2005, MNS 6272: 2011</b>
Шинжилсэн огноо	: 2022.09.120-2022.10.03
Хуудасны тоо	: 1 /2
Үр дүн	: 1

Сорьцын нэр	Ж/Б мг/л	ПИЧ мг/л	NH <sub>4</sub> мгN/л	NO <sub>2</sub> мгN/л	NO <sub>3</sub> мгN/л	PO <sub>4</sub> мгP/л	Fe мг/л	F мг/л
Найлах дүүрэг 3-р хороо Худгийн ус	9.0	3.8	0.05	0.105	2.57	0.004	0.08	0.41
<b>MNS 0900:2018</b>	-	-	<b>1.5</b>	<b>1.0</b>	<b>50</b>	<b>3.5</b>	<b>0.3</b>	<b>0.7-1.5</b>

Тайлбар: Ж/Б- Жинчлэгдэгч бодис, ПИЧ-Перманганатын Исэлдэх Чанар, ИЛР-Илрээгүй

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:



Б.Жавзандулам

Хянаж баталгаажуулсан инженер:

Ц.Мийдүв

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг 3.11. Усны шинжилгээний харуу-1



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt@gmail.com](mailto:bohzt@gmail.com)



**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№ : 2022/ Ц-171  
 Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Хэлтэргэ” ХХК  
 Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд, БОХЗТЛ  
 Сорьцын тоо, төрөл : 1, ус  
 Сорьцыг авсан огноо : 2022.09.20  
 Сорьцын тодорхойлолт : Усны сорьц  
 Шинжилгээний аргын стандарт : **MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999,  
MNS 6271:2011, MNS 4424:2005, MNS 1097:1970**  
 Шинжилсэн огноо : 2022.09.20-2022.10.03  
 Хуудасны тоо : 2 /2  
 Үр дүн : 1

Сорьцын нэр	pH	EC μS/cm	SO <sub>4</sub> мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO <sub>3</sub> мг/л	Эрд мг/л	Хат мг-экв/л
Найлайх дүүрэг 3-р хороо Худгийн ус	7.66	4440	158	1208	428	149	210	288	2441	33.66
<b>MNS 0900:2018</b>	<b>6.5-8.5</b>	<b>1000</b>	<b>500</b>	<b>350</b>	<b>100</b>	<b>30</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>7.0</b>

Тайлбар: EC - цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэсжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Б.Жавзандулам

Хянаж баталгаажуулсан инженер:

Ц.Мийдүв



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг 3.12. Усны шинжилгээний харуу-2



**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt@gmail.com](mailto:bohzt@gmail.com)



**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№	: 2022/A-271
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Хэлтэргэ” ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал	: Д.Сувд агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл	: 2 агаар ,2 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2022.9.20
Дээжийн тодорхойлолт	: Налайх дүүрэг 3-р хороо тоосгоны үйлдвэр
Шинжилгээний аргын стандарт	: MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021 CA3 A07-2016
Шинжилсэн огноо	: 2022.9.25
Хуудасны тоо	: 1/1

Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл мг/м <sup>3</sup>	Нийт Тоос /TSP/ мг/м <sup>3</sup>	Дуу чимээ /ДБА/
1	Кэмп орчим	IX/20	14:20	0.018	0.024	0.072	55
2	Баажуу орчим	IX/20	14:20	0.015	0.021	0.069	45
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:  
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан:  
Агаарын хэсгийн инженер



Э.Оюунтуяа


Д.Түмэндэлгэр

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Зураг 3.13. Агаар, дуу чимээний хэмжилтийн үр дүн

### 3.9. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Налайх дүүргийн Засаг даргын тамгын газрын хүсэлтийн дагуу 2022 оны 7-р сарын 29, 30, 31-ний өдрүүдэд Налайх дүүрэгт зохион байгуулагдсан “Төвийн бүсийн хурдан морины уралдаан”-ыг бусад аж ахуйн нэгжүүдийн хамт нийт 24 сая төгрөгөөр дэмжиж хамтран ажиллав.



Зураг 3.14. Төвийн бүсийн хурдан морины уралдааныг дэмжиж оролцсон итгэх хуудас

### 3.10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тухайн жилийн буюу 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажилласан ба холбогдох тайлбар, үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд харууллаа.

*Хүснэгт 3.4. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ*

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Хэрэгжүүлэгч	Зардал, мян.төг
1	Шаврын орд, үйлдвэрийн ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийн талаар сургалт, семинарыг тогтмол зохион байгуулсан	Жил бүр	“Хэлтрэгэ” ХХК	250.0
2	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулсан	Төслийн үйл ажиллагааны явцад	“Хэлтрэгэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
3	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан	Жилд 1 удаа	“Хэлтрэгэ” ХХК	250.0
4	Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийн гадаад орчныг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар арга хэмжээ зохион байгуулсан	Жил бүр	“Хэлтрэгэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
5	Байгаль орчны аудит хийлгэсэн	2 жил тутамд	“Хэлтрэгэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
6	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байсан	Төслийн хугацаанд	“Хэлтрэгэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
<b>Нийт дүн</b>				<b>500.0</b>

“Хэлтрэгэ” ХХК нь Налайх дүүргийн 60 гаруй иргэдийг ажлын байраар ханган үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид цаашдын үйл ажиллагааныхаа явцад ажиллах хүчнийхээ эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөлөл багатайгаар үйл ажиллагаагаа явуулах бүх шатны арга хэмжээгээ сайжруулан ажиллах болно.

### 3.11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"Хэлтрэгэ" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүргүүлж ажилладаг.

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө болон биелэлтийг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 3.5. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь*

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Нийслэлийн байгаль орчны газар, БОАЖЯ	Хорооны ИНХ	Хуралд танилцуулах	БОМТ-ийн 2022 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ний өдрийн дотор	Хорооны төв
	Дүүргийн ЗД, БОХХБайцаагч	Уулзалт			Дүүргийн төв
Төрийн захиргааны төв байгууллага	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр болон Файл хэлбэрээр	2022 оны БОМТ	12-р сарын 01-ний өдрийн дотор	УБ хот

Бид байгаль орчны менежментийн төлөвлөгөө, уг төлөвлөгөөний биелэлт болон олон нийтэд тайлагнах, байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээ мэдээллэх, сурталчлах ажлуудаа цаашид илүү сайжруулан ажиллахаар хичээж байна.

### 3.12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НЭГТГЭЛ

2022 онд БОМТ-нд нийт 4030.0 мян.төг зарцуулахаар төлөвлөсөн ба биелэлтийн гүйцэтгэлээр 7792.2 мян.төгрөг зарцуулсан буюу 193.35%-ийн гүйцэтгэлтэй ажилласан үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 3.6. 2022 оны БОМТ-ний нийт зардал, биелэлтийн үзүүлэлтүүдийн харьцуулалт*

№	Арга хэмжээ	Төлөвлөгөөнд тусгагдсан зардал, мян.төг	Биелэлтээр гүйцэтгэсэн ажлын зардал, мян.төг	Гүйцэтгэл, %
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	380.0	400.0	105%
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1500.0	1500.0	100%
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Зардал төлөвлөгдөөгүй	1000.0	+100%
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Хамааралгүй	-	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Хамааралгүй	-	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1000.0	1000.0	100%
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	500.0	534.2	107%
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	650.0	158.0	24%
9	Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	Төлөвлөгдөөгүй	2700.0	+100%
10	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Зардал төлөвлөгдөөгүй	500.0	+100%
11	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	Зардал төлөвлөгдөөгүй	Тайлагнасан	+100%
<b>Нийт дүн</b>		<b>4030.0</b>	<b>7792.2</b>	<b>193.35%</b>

## ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Хэлтрэгэ” ХХК-ний “Зүүн хэсэг” тоосгоны шаврын уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Шавар олборлолт, тоосго үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах явцад нөлөөлөлд голчлон өртөгч нь хөрс, ургамал, агаар, газрын ба геологийн тогтоц юм.

Иймд сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх зэрэг ажлуудыг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу хэрэгжүүлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан арга хэмжээг цаг тухайд нь гүйцэтгэж, үр дүнд нь дүгнэлт хийн ажиллалаа.

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийтдээ 4.030.000 (Дөрвөн сая гучин мянган) төгрөг зарцуулахаар төлөвлөгдсөн.

“Хэлтрэгэ” ХХК нь 2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хуулийн 31-р зүйлд заасны дагуу БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй. 2022 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт зардлын 50% буюу 2.015.000 (Хоёр сая арван таван мянган) төгрөгийг тусгай дансанд байршуулсан.

2022 онд БОМТ-ний биелэлтийн гүйцэтгэлд нийт 7792.2 мян.төгрөг зарцуулсан нь төлөвлөгөөнд тусгасан зардлын үзүүлэлттэй харьцуулахад 193.35%-ийн гүйцэтгэлтэй ажилласан үзүүлэлттэй байна.

Бид цаашдын үйл ажиллагааныхаа явцад байгаль орчны менежментийн төлөвлөгөө, уг төлөвлөгөөний биелэлтийн ажлуудыг холбогдох хууль, журам, стандарт, аргачлалуудад нийцүүлэн тогтмол сайжруулж ажиллах болно.